



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

“Хаан даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Хаан даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч Ч.Чимидсүрэнгийн 500,000,000 /таван зуун сая/ төгрөг, А.Мэндбаярын 150,000,000 /нэг зуун тавин сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл	
1	Ж.Баярсайхан	1,250,000,000.00	0.0	1,250,000,000.00	33.8%
2	Г.Энхбилэг	1,450,000,000.00	0.0	1,450,000,000.00	39.2%
3	А.Мэндбаяр	100,000,000.00	150,000,000.00	250,000,000.00	6.8%
4	Ч.Чимидсүрэн	100,000,000.00	500,000,000.00	600,000,000.00	16.2%
5	Г.Лхагва-Очир	150,000,000.00	0.0	150,000,000.00	4.0%
	Нийт	3,050,000,000.00	650,000,000.00	3,700,000,000.00	100%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Хаан даатгал” ХХК /Б.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000432